

## ЛАЛЫН ЕРТӨНЦ БА ТЕРРОРИЗМЫН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

*С.Дашцэвэл\**

### 1. Лалын шашин үүсч тархсан нь

Бурханы (будда) шашин, загалмайн (христос) шашин, жүүдийн (иудейн) шашин буй болсноос нэлээд хожуу нийтийн тооллын 6-р зууны эцэс 7-р зууны эхээр Лалын (ислам) шашин үүссэн түүхтэй.<sup>1</sup> Лалын шашныг үндэслэгч Мухаммад Арабын хойгийн баруун хойт нутаг Улаан тэнгисийн эрэг хавьд эдүгээгийн Саудын Арабын Мекка хэмээх хотод нийтийн тооллын 570 онд төрсөн. Жижиг худалдаачны хүү Мухаммад олон жил бяслаган сууж лалын шашны үзэл сургаалыг үндэслэн бүтээжээ. Ер Мухаммадын төрөлх нутгийнхан өвөрмөц зан заншил, соёлтой, түүгээрээ бахархах сэтгэл нэн ихийн учир загалмайн болон жүүдийн шашин хил залгаа байсан хэдий ч тэнд нэвтэрч чадаагүй гэдэг. Тэр ч байтугай Энэтхэгийн Ашока хааны үед Бурханы шашныг дэлгэрүүлэх элч нар Саудын Арабт хэд хэдэн удаа очсон хэдий ч түүнийг тас эсэргүүцэн буцаасан удаатай.

Мухаммадын үндэслэсэн лалын шашин нь нутгийн өвөрмөц соёлын тусгал, түүний уламжлалт зан заншил, үзэл ойлголтонд тулгуурласан бөгөөд бусад соёл, шашин суртахууныг огтхон ч ойшоодлоггүйн дээр Мухаммад багштан “Дэлхий ертөнцөд ганцхан тэнгэр бурхан байдаг нь Аллах, Аллах тэнгэрийн элч нь Мухаммад өөрөө” хэмээн айлджээ. Лалын сүм гэхэд дотор нь нэгээхэн ч шүтээний хөрөг барималгүй хов хоосон орон зай байдаг нь сансрын орон зайг хураангуйлсан хэрэг аж.

Лалын шашны нэг онцлог нь сүсэгтэн хүн шашныхаа тогтсон дэг журмыг хатуу чанд баримтлах ёстой. Лал сүсэгтний үйлдэх ёстой зарим ёс дэгээс дурдвал: өдөрт наад зах нь хэд хэдэн удаа мөргөл үйлдэх тогтсон цаг хугацаатай. Жилд нэг удаа бүтэн сараар мацаг барих ёстой. Тэр хүн мацагийн үеэр нар ургах ба жаргахын хооронд буюу гэгээн цагаан өдрөөр юу ч идэх ёсгүй. Мацагийн сар буюу армадан сараар Аллахын ариун дагшин орон Мекка руу эргэл мөргөлийн аянд гарах ёстой. Армадан сарын 26-27-нд шилжих шөнө Аллах тэнгэрийн коран сургаал Мухаммадад заларч ирсэн хэмээн лалынхан үздэг учраас энэ сарыг нэн хүндэтгэлтэй бөгөөд ёс төртэй үлдэг ажээ.<sup>2</sup> Энэ шашныг дагагсад архи, тамхийг бүрэн цээрлэхээс гадна ариун шашны төлөө

\*С.Дашцэвэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

амиа золиослоход бэлэн байх ёстой. Лалын хууль нэн хатуу. Хулгай хийсэн, худал хэлсэн, дээрэм тонуул үйлдсэн, шашин суртахуунаасаа урвасан гэх мэт бүхий л том бага хэрэгт хуруу гараа тас цавчуулахаас эхлээд алах ял хүртэл оногдуулна.

Лалын шашны сургаал үүсч байсан VI-VII зууны заагт Арабын баруун эрэг буюу Персийн булан олон улсын стратегийн чухал байршилтай 3 тивийн худалдаа эдийн засгийн төв болж байсан явдал лалын шашин тархах нөхцлийг нэн сайн бүрдүүлжээ. VII зуунаас XVI зууны эх хүртэл лалын шашин дэлхийн олон оронд маш түргэн тархаж, бурханы болон бусад шашныг хүчтэй түрэн Дунд Ази, Төв Ази, Өмнөд Ази, Африк, Латин Америкт нэвтэрчээ. Эдүгээ манай дэлхий дээр лал шашинтны тоо 1 тэрбум орчим бөгөөд 5 тивийн 70 гаруй оронд тархжээ.<sup>3</sup>

## 2. Олон урсгалд хуваагдсан нь

Мухаммадын нас нөгцсөний дараа түүний үе үеийн шавь нар лалын шашны сургаалыг баяжуулж өөр өөрийн хувь нэмрийг оруулсаар лалын шашныг олон урсгал чиглэлтэй болгожээ. Гэхдээ лалын шашинд шийт, суннит гэсэн үндсэн 2 чиглэл бий. Чухамдаа нэг нь уламжлалыг дагасан нөгөө нь шинэчлэлийг чухалчилсан хоёр чиглэл гэж ойлгож болно. Лалын шашны олон урсгал байвч энэ л хоёр үндсэн чиглэлийн аль нэгт харъяалагдана. Уламжлалыг баригч шийтүүд, шинэчлэлийг дэмжигч суннитын хооронд шашны болон улс төрийн тэмцлүүд хэдэн зууны турш үргэлжилсээр байна. Дэлхийн II дайнаас хойш энэ хоёр үндсэн урсгалын тэмцэл улам хурцдаж шинэчлэлийн талынхан олон оронд амжилт олжээ. Уламжлалын талыг барьсан шийтүүдийн ихэнх нь тулгуур үзэлтнүүд бөгөөд Умард Африк хавьд төвлөрч байв. Гэвч хүйтэн дайн төгсөх үед Баруун Ази, Дунд Азид хүчний харьцаа өөрчлөгдөж, тэнд зарим их гүрнүүдийн нөлөө суларч хоосон зай үүсэн нь Турк Иран зэрэг лал шашинт хөгжингүй орнуудын нөлөө, үзэл бодлын чөлөөт байдал ихсч, улмаар жижиг үндэстнүүдийн дунд бие даах үзэл сэргэхийн хамт лалын ариун төр ёсыг сэргээх гэсэн лоозонтой тулгуур үзэл өндийх аян шалтаг болжээ.

Үүнээс үүдэн Дундад Азийн хэд хэдэн оронд тулгуур үзлийг дэврээн дэмжигчид засгийн эрхийн төлөө тэмцэл өрнүүлж, бүс нутгийн улс төрийн байдлыг тогтворгүй болгон зөрчил мөргөлдөөний талбар болгожээ. Ийм зөрчлийн нэг голомт нь 90-ээд оны Афган орон юм.

### **3. Афганичууд ба Талибууд**

Төв Азийн баруун өмнөд хэсэгт орших Афганчууд эртний түүхтэй ард түмэн бөгөөд бүр нийтийн тооллын өмнөх 6-р зуунаас түүхэнд нэр нь дурсагддаг ажээ. Энэ ард түмэн Перс, Грек, Энэтхэг, Иран, Монгол зэрэг үе үеийн имперүүдийн эзэмшил болж (бараг нэгэн зууны турш монголын империйн мэдэлд байсан) байсан агаад 17-р зуунаас үндэсний төр улсаа сэргээн төвхнүүлсэн хэдий ч том гүрнүүдийн соронзон орны таталцалд байнга өртөгдсөөр XX зууны эцэст иргэний дайны нэгэн том талбар болсон билээ. Афганистан дахь иргэний дайны үед лалын урсгалууд засгийн эрхийн төлөө өвөр хоорондоо тэмцэлдэж, эцэст нь Талибууд хэмээх лалын нэгэн хүчин засгийн эрхэнд гарав. Талибууд бол Өмнөд Афганистаны Батаан омгоос гаралтай бөгөөд Баруун Хойд Пакистанд нэг хэсэг нь суудаг аж. Батаан омгийнхон эртний уламжлалаа төдийлөн орхиогүй ер бусын дайчин омог гэнэ. Пакистаны эрт эдүгээгийн цэргийн жанжнууд /Аюуб Хан, Яхья Хан гэх мэт/ энэ л омгоос гаралтай гэнэ. Талибуудын ихэнх нь залуучууд оюутнууд байсан бөгөөд Кабул хотыг бүсэлж Ерөнхийлөгч Бурхануддын Раббаний болон Ахмад Шах Масудын засгийн газрыг унагааж оронд нь лалын тулгуур үзэлтний засгийн газрыг байгуулж бусад шашин омгийн эсрэг ширүүн тэмцэл өрнүүлэв. Тэд лалын уламжлалт хатуу ёс дэгийг Афганистаны нийгэмд тулган хүлээлгэж эхлэв. Мөн тэрс үзэлтний эсрэг ариун дайн зарлаж, орон нутгийн сүсэгтнүүдийг үзэл бодлоор нь ялгаварлан цээрлүүлж, сүсэг бишрэлгүй харь орны хүмүүс ялангуяа Америк болон Өрнөдийнхөний эсрэг эрээ цээргүй дайрч давшлан алан хядах ажиллагааг үйлдэв. Тэдгээр тулгуур үзэлт талибуудыг лалын шинэчлэгчид буюу ихэнх суннит урсгалынхан эсэргүүцэж байв.

### **4. Лалын хэт даврагсад ба олон улсын терроризм**

Лалын хэт даврагсад гол нь тулгуур үзэлтнүүдээс бүрэлдэх бөгөөд тэд лалын ариун ёсны төлөө нэрийн дор хүчирхийлэл хэрэглэж, алан хядах явууллагыг дэвэргэж байна. Эдгээр хэт даврагсдыг улс төрийн хонзогногч хүчнүүд гар хөлөө болгон ашиглаж, алан хядах ажиллагаанд татан оролцуулсаар олон улсын терроризмыг бий болгожээ. Өөрөөр хэлбэл олон улсын алан хядагчдын ар талд шашинаар халхавч хийсэн улс төрийн аль нэг хүчний хонзогногчид зогсч, алан хядах ажиллагаанд турхиран санхүүжүүлж байдаг аж. Тэрхүү явуулгад Аллахын төлөө амиа золиослоход бэлэн гэсэн лалын шашны номлолд хоосон итгэгчид хамгийн хялбар ашиглагддаг байна.

### **5. Осамо Бин Ладен ба Аль Кайдо бүлэг**

Осамо Бин Ладен бол Саудын Арабын тэрбумтан. Лалын хэт даврагсдыг өөгшүүлэн тэтгэгч нэгэн. Тэрбээр Ойрхи Дорнод, Ази дахь лалын бус засгийн газруудыг хүчирхийлэл, алан хядах аргаар эсэргүүцэн тэмцэх зорилготой Аль Кайдо бүлгийг 1985 онд байгуулсан. Тэр үеэс хойш Аль Кайдо бүлгийн эгнээ үлэмж өсч дэлхийн олон оронд бүхэл бүтэн сүлжээ бүхий олон байгууллага, олон зуун мянган хүнийг хамрах болжээ.<sup>5</sup> Алан хядах ажиллагаагаар мэрэгшсэн түүний гишүүдийн тоо хэдэн зуун мянгад хүрэх бөгөөд дайчдаа бэлтгэдэг нүсэр том сургалтын баазууд нь олон оронд байдаг гэлцдэг.

1998 онд Кени, Танзани дахь АНУ-ын элчин сайдын яамдыг дэлбэлж хэдэн зуун хүний амь нас хороосон, 2000 онд Йеменд АНУ-ын хөлөг онгоцыг дэлбэлсэн, 2001 онд Нью Йорк дахь дэлхийн худалдааны цамхагийг онгоцоор мөргүүлэн дэлбэлж олон мянган хүний амь насыг хороосон, мөн бусад олон оронд алан хядах ажиллагаа үйлдсэн хэргийн гол эзэн буюу тэдгээр хэргийг зохион байгуулан удирдагч нь Осамо Бин Ладен болон түүний хамсаатнууд хэмээн дэлхийн олон нийт үзэж хэдэн жилийн турш эрэн сурвалжилж, самнан хайж байна.

### **6. Олон улсын терроризмын эсрэг тэмцэл**

Эдүгээ дэлхий даяар олон улсын эдгээр алан хядагчдын эсрэг хөдөлгөөн өрнөж тэдний хорлон сүйтгэх явууллагыг газар сайгүй эсэргүүцэж байна. Тэдэнтэй хэрхэн яаж тэмцэх талаар дэлхийн хамтын нийгэмлэг, засгийн газрууд, дэлхийн олон нийт санаа бодлоо нэгтгэж байна. Дэлхий нийтээрээ олон улсын алан хядагчтай эрс шийдэмгий тэмцэл хийж оршин байх үндэсийг нь таслахыг мэрийж байна. Учир нь энэ бүхэн улс орон бүрийн аюулгүй байдалтай холбоотой юм. Гэхдээ терроризмын эсрэг тэмцэл нэн төвөгтэй бөгөөд амар биш зүйл гэдэг нь нийтэд тодорхой болжээ. Юун гэвэл түүнд хил хязгаар гэж үгүй. Нөхөр дайснууд нэг дор мөр зэрэгцэн оршдог. Чухамдаа түгшүүрт байдлыг дэлхийн аль ч өнцөгт ямар ч үед ямар ч хэлбэрээр (үзүүлж болох хор хөнөөлийг урьдчилан таамаглах аргагүй) өдүүлж болох тив дэлхий хамарсан шинжээрээ нэн аюултай бөгөөд уламжлалт дайны тухай төсөөллийг үндсээр нь өөрчилж байна. Өөрөөр хэлбэл олон улсын терроризм газар авбаас дэлхийн хэмжээний түгшүүрт байдал бий болж, үндсэндээ дэлхийг дайны байдалд оруулах юм.

Терроризмын шалтгааныг дэлхийн олон нийт янз янзаар үзэж байна. Ядуурал, тэгш бус хөгжлийн үр дагавар хэмээн нэг хэсэг нь үзэж байхад нөгөө хэсэг нь соёл хоорондын ялгаа, иргэншлийн зөрчлөөс үүдсэн, өөрөөр хэлбэл үндэсний болон шашны онцлогоо хадгалахын тулд том гүрний түрэмгий, дээрэнгүй бодлогыг эсэргүүцсэн тэмцлээс улбаатай гэх мэтээр тайлбарлаж байна.<sup>8</sup>

Тийм учраас терроризмаас ангижрах арга замыг хүчирхийллээр устгахын төлөө нэг хэсэг нь байхад нөгөө хэсэг нь улс түмний хөгжлийн түвшинг ойртуулах, өөр соёл, өөр итгэл үнэмшилд уян хатан хандах замаар асуудлыг шийдэхийн төлөө байна.

Сүүлийн үед дэлхийн эрдэмтдийн дунд юуг террорист ажиллагаа гэх вэ? юуг түүний эсрэг тэмцэл гэх вэ? гэдэгт хариу эрж маргалдсаар байна. Терроризмын эсрэг тэмцэл өөрөө үй олныг хамруулан устгагч террорист ажиллагаа болж хувирахыг үгүйсгэхгүй байна.

Цэрэг зэвсгийн их хүчээр аливаа оронд цохилт өгөх арга зам хирээс хэтэрвэл тийм ч оновчтой биш бөгөөд дайныг эсэргүүцэгчдийн эгнээг өргөжүүлж, лалын хэт даврагсдыг ямар нэг байдлаар өөгшүүлэхэд хүрч, дайныг үр ашиггүй сунжруулах, эцэстээ ялагч ялагдагч гэж үгүй мухардалд орж магад хэмээн дэлхийн олон нийт болгоомжилж байгаа.

## **6. Монгол Улс ба лал шашинт хөршүүд**

Монгол Улс баруун талдаа БН Казахстан улс, Дунд Ази, Төв Азийг хамарсан бүхэл бүтэн лалын ертөнцтэй, өөрөөр хэлбэл Төв Азид дахин сэргэж буй лалын соёл иргэншлийн бүстэй хил залгаа оршдог. Энэ нь лалын ертөнцөд болж буй үйл явцыг нягтлан судалж түүнд өөрийн гэсэн байр суурьтай, тов тод бодлоготой хандахыг биднээс шаардаж байна.

Монголын хүн амын 0,4%-ийг эзэлдэг казах үндэстэн лал (ислам) шашинтай бөгөөд тэд олон арван жилээр сүсэг бишрэлээсээ хөндийрсөн тул лалын шашныг шүтэн бишрэхээсээ илүү уламжлалт соёл талаас нь хүндэтгэн ханддаг онцлогтой. Монголын лал шашинтнуудад тулгуур үзэл, хэт даврагсдын үзэл санааг хүлээн авах нийгмийн хөрс, бусад шалтгаанууд байхгүй.

Монголын хил залгаа оршдог лал шашинт Шинжаан /Синьцзян/ уйгаруудын хувьд олонхи нь лалын шинэчлэгч суннит урсгалынхан ажээ. Энэ нь Талибууд шиг тулгуур үзлийг шүтэгчид биш

гэсэн үг. Гэхдээ Афганистан, Пакистан, Иран, Туркт байгаа лалын зарим тулгуур үзэлтнүүдийн нөлөө хил залгаа лалынханд нэвтрэн тархах аюулыг үгүйсгэх аргагүй.

Шинжаан уйгур, Чечень зэрэг нутаг оронд лалын салан тусгаарлах бүлгүүд байдаг. Тэр нь талибан зэрэг зарим хөдөлгөөний нам бүлгүүдтэй холбоо сүлбээтэй боловч гол нь үндэсний эрх чөлөөний тэмцэгчид хэмээн ихэнх шинжээчид үздэг ажээ.

Орчин үед аливаа жижиг үндэстэн тусгаар тогтнох эсвэл аль нэг улс гүрний салшгүй хэсэг байх эсэх нь өөрийн хэрэг бөгөөд түүнийхээ төлөө тэмцэх нь ч үндэстний эрхийн асуудал. Улс орон улс төрийн тогтвортой байдлаа хэрхэн хамгаалах нь ч тухайн улс гүрний асуудал. Гэхдээ орчин үед үндэстэн бие даах гэсэн хөдөлгөөнийг буюу ер үндэстний асуудлыг хэрхэн яаж гаргуулахгүй зөв зохицуулах нь үндэстний эрхийг үл зөрчих тэдний өвөрмөц соёл иргэншлийг хүндлэх, үл ялгаврлах, тухайн үндэстэн тогтвортой хөгжих нийгэм эдийн засгийн бүхий л боломж нөхцөлийг үндэстний олонхиос дутуугүй хангаж өгөх зэрэг үндэстний язгуур эрх ашгийн асуудалтай нягт холбоотой шийдвэрлэх хандлага зонхилж байна. Харамсалтай нь улс гүрэн бүхэн адил биш ажээ. Зарим нь тухайн бодлогыг хүлээн зөвшөөрдөг авч түүхэн нөхцөл, уламжлал, оюун санаа, ёс зүйн хэм хэмжээ, хөгжлийн хүрсэн түвшин, эдийн засгийн боломжоос болж биелэгдэхгүй байхад зарим улс гүрэн үндэстний бодлогод өрөөсгөл хандаж, хатуу бодлого хүчирхийллээр цөөнхийг тогтоон барихыг эрхэмлэх жишээтэй. Ялангуяа лалын тулгуур үзэлтнүүд болон хэт даврагсдын үйл ажиллагаа газар авч олон улсын алан хядах ажиллагааг дэвэргэж улс үндэстнүүдийн аюулгүй байдалд занал учруулж байгаа өнөө үед лал шашинт үндэстний үндэсний эрхийн төлөөх тэмцлийг лалын хэт даврагсдын ажил явуулгатай хутган хольж түүнийг нугачан дарах явдалд аян шалтаг болгох магадлал нэмэгджээ. Иймд өнөөгийн алан хядах ажиллагаа нь олон улсын харилцаанд бас нэг ээдрээ түвэгтэй асуудлыг үүсгэж буйг харуулж байна.

### ДҮГНЭЛТ

Лалын ертөнцөд 1980-аад оноос тулгуур үзэлтнүүд өндийж Ойрхи Дорнод, Дундад Азийн зарим улс орны улс төрийн байдалд хүчтэй нөлөөлж лалын хэт даврагсдын алан хядах ажил явуулга олон улс орны аюулгүй байдалд занал учруулах болсон нь дэлхий нийтийг түгшээж хатуу байр суурь баримтлан тэмцэгчид, аядуу болгоомжтой

хандагчид, лалын нэр төрийг барьж илэрхий өмгөөлөн хамгаалагчид гэх мэтээр хуваагдахад хүрэв. Энэ байдал даамжирвал дэлхийн улс орнууд дахин үзэл бодол, байр сууриараа хуваагдаж хүйтэн дайны хямралт үе эхлэхэд хүргэнэ.

Ийм байдлын босгонд бид тулаад байна. Израйл-Палестин, АНУ-Ирак, Энэтхэг-Пакистаны байдал үүнийг гэрчилж байна. Иймд улс орон бүрийн засгийн газрууд, гадаад бодлогыг тодорхойлогчид өнөөгийн дэлхийн байдлыг ултай судалж, дэлхийн дайн үүсэхээс болгоомжлохыг цаг үе шаардаж байна.

Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдалд лалын ертөнцийн зүгээс нөлөөлөх аюул занал нэн хязгаарлагдмал юм. Гэхдээ дэлхийн хамтын нийгэмлэгийн хамт лалын хэт даврагсдын эсрэг, олон улсын терроризмын эсрэг нэгдэн тэмцэх нь бүс нутгийн төдийгүй дэлхийн улс түмний аюулгүй байдлын эрх ашигт нийцнэ.

Харин хэрхэн яаж тэмцэх вэ? гэдэг өөр асуудал. Энд өөрийн гэсэн байр суурийг тодорхойлох ёстой. Үйл явцын өрнөлт хийгээд цаг үеийн нөхцөлд тохирсон уян хатан, ухаалаг бодлого, байр суурьтай баймааж дэлхийн энхийн үйлсэд хувь нэмрээ оруулж чадна.

### **Ашигласан материал**

1. Монголчууд исламын шашныг дээр үеэс лалын шашин хэмээн нэрлэж заншсан нь Аллах хэмээх үгнээс сунжирсан үг ажээ. Мөн еврей нарын иудейн шашныг жүүдийн шашин, буддын шашныг бурханы шашин, христийн шашныг загалмайн шашин хэмээн монгол бичгийн хэлэнд нэрлэж бичиж хэвшсэнийг ёсоор болгов.
2. Nghien cuu quoc te 1996 №11
3. Thong tin tu lieu Hanoi 2001, pp.34-35
4. News letter, march 2001
5. А.Жамбал, Ислам: шашин, философ казакчуудын нийгмийн сэтгэлгээ УБ. 1999
6. Өдрийн сонин 2001.11.23, №278
7. [www.isim.nl](http://www.isim.nl)
8. Chu nghia khung bo (Терроризмын тухай өгүүлэх нь) Hanoi, 2002. 163р.